Платформын Удирдах Хорооны Хурал-II

Нэр: Монголын Тогтвортой Ноолуурын Платформ

Байршил: НҮБ-ын байр, 6-р давхрын хурлын танхим

Огноо: 2020 оны 9-р сарын 18-ны өдөр, 09:00-11:00 цаг

Хурал удирдсан: Илейн Конкиевич, НҮБХХ-ын Суурин төлөөлөгч

Оролцогчид: Ирц – оролцвол зохих 8 хүнээс 7 буюу 87.5%

№	**Төслийн удирдах хорооны гишүүд**	**Гишүүн бус**
Оролцсон	1. Илейн Конкиевич, НҮБХХ-ын Суурин төлөөлөгч	9. Х.Хишигжаргал, Шинжээч, НҮБХХ, 10. В.Шинэнэмэх, Менежер, МТНП 11. О.Одгэрэл, Мэдээлэл, Харилцааны Менежер, МТНП 12. Н.Цолмон, Ажилтан, МТНП
	2. Б.Бадруун, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, ХХААХҮЯ 3. Ц.Эрдэнэбат, Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын Эдийн засаг, аж үйлдвэрийн бодлогын асуудал хариуцсан зөвлөх, Ерөнхийлөгчийн Тамгын Газар 4. Т.Булган, БОАЖЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	
	5. А.Амгалан, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Техникийн зөвлөх	
	6. Д.Алтанцэцэг, Монголын Ноос Ноолуурын Холбооны гүйцэтгэх захирал 7. Н.Ганхуяг, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал	
	8. Ц.Энх-Амгалан, GGAHP, Зөвлөх хорооны төлөөлөл	
Оролцоогүй	1. М.Дондогдорж, Хөнгөн Үйлдвэрийн Хөгжлийн Бодлогын Хэрэгжилтийг Зохицуулах газрын дарга, ХХААХҮЯ	

Удирдах хорооны хурлаас гарах үр дүн:

1. Нэгдсэн Хуралдаан зохион байгуулахтай холбоотой шийдвэрүүд;
2. Платформын Мэдээлэл Харилцааны Стратегийг батлах;
3. Гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнг хэлэлцэх;
4. 2020 оны 9-12-р сарын ажлын төлөвлөгөө, төсвийн тодотголыг хэлэлцэж батлах

ХӨТӨЛБӨР

Цаг	Арга хэмжээ	Хөтлөгч/илтгэгч
08:30-09:00	Бүртгэл, кофе цай	
09:00-09:10	Удирдах хорооны хурлын нээлт, хөтөлбөрийг танилцуулах	Илейн Конкиевич, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч
09:10 –09:30	Платформын ажлын явц, үр дүнгийн талаар Удирдах Хорооны гишүүдийн санал	В.Шинэнэмэх, Платформын менежер
09:30 –09:40	9-12 сард төлөвлөсөн ажлын талаарх санал, зөвлөмж, шүүмж	В.Шинэнэмэх, Платформын менежер
09:40 –10:00	Нэгдсэн Хуралдааны тухай хэлэлцэж, шийдвэр гаргах	Х.Хишигжаргал, Хөтөлбөрийн шинжээч В.Шинэнэмэх, Платформын менежер
10:00 –10:20	Платформын Мэдээлэл Харилцааны Стратегийг танилцуулж батлах	О.Одгэрэл, МХ-ны Менежер
10:20 –10:40	2021 оны ажлын чиг баримжаа	В.Шинэнэмэх, Платформын менежер
10:40 –10:50	Хаалтын үг	Илейн Конкиевич НҮБХХ СТ
10:50 –11:00	Зураг авахуулах	

Хэлэлцүүлгийн хураангуй

Хурлыг нээж НҮБХХ-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Илэйн Конкиевич үг хэлэв.

И.Конкиевич, Монгол дахь Суурин төлөөлөгч, НҮБХХ: Юуны өмнө өнөөдөр Монголын Тогтвортой Ноолуурын Платформын Удирдах Хорооны гишүүд та бүхэнтэй хамт ээлжит хурлаа хийх гэж байгаадаа баяртай байна. Энэ удаагийн хуралд тодорхой шалтгааны улмаас буюу гадаадад буй гэр бүл дээрээ очоод ирсний дараа тусгаарлалтанд байгаа учраас биечлэн оролцох боломжгүй болсондоо хүлцэл эрье. Платформын өнгөрсөн хагас жилийн ажлын тайланг хэлэлцэх энэхүү чухал уулзалтанд цаг заваа зарцуулан хүрэлцэн ирсэн та бүхэнд маш их баярлалаа! НҮБХХ-ийн хувьд Монгол улс болон Монголын ноолуурын салбар нь тэргүүн зэргийн ач холбогдолтой чиглэлүүдийн нэг юм. Монгол дахь төлөөлөгчийн газар нь уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн менежмент зэрэг асуудлуудад онцгойлон анхаарч, ноолуурын салбарын Монголын эдийн засаг болон уламжлалт, нүүдэлчин мал аж ахуй дахь онцгой үүрэг ролийг ойлгохын зэрэгцээ малчдын амьдралын хэв маяг, амьжиргааг дээшлүүлэх, Монгол улсын өв соёлыг хамгаалах

боломжыг бид үргэлж эрэлхийлж байдаг. Энэхүү Платформ нь ноолуурын салбарт ажиллаж буй олон талт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын харилцан уялдааг нэгтгэх, хамтын хүчин чармайлтыг бий болгох зорилготой байгуулагдсан билээ. Бид хамтран ажилласнаар илүү их амжилтанд хүрнэ гэж итгэж байгаа учраас энэхүү үйл явдлыг эерэг өөрчлөлтийн эхлэл гэж үзэж байна. Тиймээс ноолуурын Платформын үйл ажиллагаанд оролцох таны оролцоо, хувь нэмэр, санаа бодол зүйрлэшгүй үнэтэй билээ. Ингээд хурлыг албан ёсоор эхлүүлж байгааг хүлээн авна уу.

В.Шинээ, МТНП: Хурлын хөтөлбөр, хэлэлцэх үндсэн 4 асуудал болон 2021 онд 8 зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөснөө танилцуулав. Мөн 2020 оны 8 сарын байдлаар цаг үеийн нөхцөл байдал, тодорхой шалтгаануудын улмаас цуцлагдсан, хойшлогдсон ажлуудын улмаас Платформын 2020 оны санхүүжилт болох 306,000 USD-ийн 9% нь зарцуулагдсан гэдгийг, он дуустал 240,00 USD орчмын гүйцэтгэл шаардлагатай байгаа бөгөөд Платформын баг энэхүү гүйцэтгэлд хүрэхийн тулд чармайн ажиллана гэдгээ илтгэв. Мөн түүнчлэн ENSURE төслийн Удирдах Хорооны хурлаар төсөвлөгдсөн санхүүжилтийн үлдэгдлийг дараа жил рүү шилжүүлж болох эсэхийг хэлэлцүүлнэ гэдгийг дуулгав. Хамтын ажиллагааны хэд хэдэн үе шатууд байдаг бөгөөд Платформын үйл ажиллагаа нь хамтрах, хамтран зохицуулах шатанд ирсэн, цаашид ч энэ түвшнийг улам ахиулахын төлөө ажиллах болно гэв.

Т.Булган, БОАЖЯ:Төслийн багийнхан өнгөрсөн хагас жилд идэвхи зүтгэлтэй, үр дүнтэй ажилласан болохыг сонслоо. ENSURE төсөл санхүүжүүлж, дэмжиж ажиллаж байгаа. Ажлын үр дүн, индикаторууд бодитой ажлаар илэрхийлэгдэх ёстой байх. Платформ дөнгөж эхлэх шатандаа яваа ч Платформын багаас гадна бусад багууд хэр идэвхитэй байгаа нь сайн харагдахгүй байна. МУ-ын “Урт хугацааны бодлого 2050”-ын 6-р бүлэг, Ногоон хөгжил хэсэгт тогтвортой бизнесийн Платформ, тогтолцоог бий болгох заалт орсон байгаа. Манай БОАЖЯ-ны зүгээс банкны салбартай хамтран ажиллаж тогтвортой санхүүгийн зарчим, үүнтэй холбоотой хууль, гарын авлага, удирдамжууд боловсруулж тогтвортой бизнесийн чиглэлээр сургалтуудыг зохион байгуулсан. Өмнөх УХ-ны хурал дээр хэлж байсанчлан, МУ-ын нэг баялаг бол олон янз экосистемтэй, байгалийн баялаг, тэрэн дээр суурилж үр өгөөжийг нь хүртдэг МАА салбарын бүтээгдэхүүн юм. МАА салбар тогтвортой, эрсдэл багатай байхын тулд эх үүсвэр буюу бэлчээрийг нь хамгаалах, бэлчээрийн даацын асуудлыг шийдэх хэрэгтэй. Нөгөө талд нь, боловсруулалтын явцад үүсэж буй хог хаягдлын асуудал. Боловсруулж буй тодорхойлолтондоо эдгээр зарчмууд, байгальд ээлтэй байх, ОУ-д мөрдөгдөж байгаа стандартууд, Монголын стандартуудыг судалж нарийн тусгаж өгөх хэрэгтэй. Улсын хэмжээнд усны тухай хуулинд тусгайлан заасан хоёр стандартыг АА үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниуд мөрдөхийг шаардана. Энэ мэдээллийг ноос, ноолуурын салбарынхан сайн түгээж хаягдлыг бууруулах, стандартыг мөрдөх чиглэлээр ажиллаасай, гүйцэтгэх ёстой 200-аад мянган долларыг энэ чиглэлд зарцуулаасай гэж хүсэж байна. Мөн түүнчлэн Ковид-той холбоотой 50,000 долларын санхүүжилтийг ямар байдлаар зарцуулах гэж байгаа вэ? Тодорхой үр дүнгүүд гараасай, анхаарал тавьж ажиллаасай гэж хүсэж байна.

В.Шинээ, МТНП: Таны саналуудыг тэмдэглэж авлаа. Ковидын улмаас тулгараад байгаа асуудлыг хэрхэн шийдэх, хамтын ажиллагааг хэрхэн хангах, системийн өөрчлөлтийг яаж хэрэгжүүлэх талаар хамтын ажиллагаанд суурилсан ажиллагаанд зарцуулж байгаа. Салбарт дутагдаад байгаа нэг асуудал нь хамтын ажиллагаа, хамтын шийдэл байгаа учраас энэ чиглэлд ажиллаж байгаа.

Х.Хишигжаргал, НҮБХХ: Бүлгийн даргын асуултанд тодруулга хариулт өгөхөд Ковид-ын үед салбарт тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн даван туулж, шийдэх вэ гэдэг чиглэл гаргахын тулд олон талт оролцогчдыг хамарсан хэлэлцүүлэг хийгээд, эхний ээлжинд хэрэгжүүлэх боломжтой ямар арга хэмжээ байгааг тодорхойлоод, тэрнийхээ хүрээнд яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлон шийдэлд хүрч тэр хурлын материалыг эцэслэн анализ, дүн шинжилгээ хийгээд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө гаргасан байгаа. Хэлэлцсэн ажлынхаа үр дүнг бодит болгоно гэсэн үг.

Н.Ганхуяг, МБАНХ: Манай байгууллагын зөвлөхүүд Платформын зүгээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд оролцоод явж байгаа. Ковид-ын улмаас хөдөө орон нутагт хийхээр төлөвлөж байсан хэд хэдэн арга хэмжээ цуцлагдсан. Хэдий тийм боловч нөхцөл, бололцоогоо дайчлан онлайнаар зарим ажлаа амжуулсан. Хөдөө орон нутаг, малчид, хоршоодод Платформын үйл ажиллагаа, зорилго чиглэл, хийгдэж буй ажлууд, тогтвортой ноос, ноолуурын талаарх мэдээллийг цаг алдалгүй хүргэх хэрэгтэй байгаа. Малчдын болон Хоршоод, Холбоодын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, сургалт явуулах, мэдээлэл хүргэх талаар ямар төлөвлөгөө байгаа вэ?

В.Шинээ, МТНП: Тийм ээ, энэ бол манай Платформын ажлын чухал хэсгүүдийн нэг. Бид ENSURE төслийнхний хамт 10 сарын эхний долоо хоногт анхны орон нутгийн ажил төлөвлөсөн байгаа. Баянхонгор аймгийн Шинэжинст сум, Архангай аймгийн 1, 2 суманд очиж ажиллан малчдад Платформын үйл ажиллагаа, тухайн орон нутагт тогтвортой ноолуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төслүүдийн сайн туршлагатай танилцах, нөхцөл байдал ямар байгааг газар дээр нь үзэж судлахаар явах гэж байна. Зөвлөх Хорооны хурлыг 2 хоногийн өмнө хийсэн. Энэ хурлын үеэр Зөвлөх хороотой хамтран хөдөө орон нутагт онлайн байдлаар хамтран ажиллах талаар санал солилцсон. Цахим сургалтын материал бэлдэх, хамтран цахим сургалтын data base бэлдэх талаар маш үр дүнтэй санал солилцоод тохиролцсон байгаа. Мөн бидний төлөвлөснөөр 21 онд маш шинэлэг, инновацилаг арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байгаа. Энэ талаар илтгэл бэлдсэн байгаа тул танилцуулах болно.

В.Шинээ, МТНП: 2021 оны ажлын чиглэлээ танилцуулав.

Д.Алтанцэцэг, МННХ: Платформын ажлын хүрээнд олон төсөл, хөтөлбөрүүд ажлын хэсэг байгуулаад нэг ширээний ард суун тогтвортой ноолуурын чиглэлээр хэлэлцэж зөвшилцөж байгаа нь Плафтормын ажлын амжилттай эхлэл гэж үзэж байна. Платформ олон ажил төлөвлөсөн байна. Хамтын ажиллагаанд учирч байгаа хүндрэлүүд, цаашид хэрхэн өргөжүүлэх талаар дүгнэлт хийгээд гаргаад ирвэл ерөнхий суурь нь босоод ирэх байх. Тоонд биш чанарт суурилсан бизнес руу шилжих, энэ процессыг хурдасгах тал дээр Платформ томоохон зорилт тавьж ажиллаж байгаа. Энэ ажлуудын хүрээнд Төр, хувийн хэвшил, ОУ-ын байгууллагууд, ЭШ байгууллагуудын олон талт нягт хамтын ажиллагааны хүрээнд МННХ дэргэд баталгаажуулалтын албыг бий болгосон. Гол зорилго нь түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн хүртэлх өртгийн сүлжээ тус бүрт чанарын хяналтыг бий болгох, чанарын хяналтын тогтолцоог бий болгох, ОУ-ын стандартыг нутагшуулах, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай текстилийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд баталгаажуулалтын чиглэлээр оролцож ажиллана. Түүнчлэн Монгол ноолуурын чанарыг баталгаажуулах нь бас нэг эрхэм зорилт. Салбарт хэрэгжиж буй олон талт оролцогчдын эхлүүлсэн санал санаачлага, үр дүнг цаашид тогтвортойгоор үргэлжлүүлэх, чадавхижуулах, дэмжих тал дээр анхаарч өгөөч гэж хүсье. Мөн ОУ-ын зах зээлтэй холбож өгөх, гадаад худалдааг өргөжүүлэх, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх талаар анхаарч

ажиллахыг хүсье. Түүнээс гадна Ганхуяг захирлын хэлсэнчлэн, чадавхи нэмэгдүүлэх, гадны сайн туршлагыг нэвтрүүлэх, бүх талуудад ашигтай уян хатан механизм бий болгох, хүний нөөцийг чадавхижуулах сургалт зохион байгуулах шаардлагатай байна гэдэг санал байна.

Ц.Энх-Амгалан, НАМЭМ: Манай төслөөс Платформын Зөвлөх Хороонд орж ажиллаж байгаа. Манай төслийн хувьд сүүлийн 16-17 жил тогтвортой ноолуурын чиглэлээр ажиллаж байна. Тогтвортой ноолуур ярихын тулд Монгол орны газар нутгийн 70-80%-ийг эзэлдэг бэлчээрийн тогтвортой менежментийн талаар ярих ёстой. Өнөөдрийн байдлаар нийт бэлчээрийн 65% нь доройтсон. Иймэрхүү байдлаар дахин 5 жил өнгөрөхөд энэ хэмжээний газар нутаг, бэлчээр бүрмөсөн цөлжих аюул тулгараад байгаа. Өөрөөр хэлбэл бэлчээрийн даацын асуудал, бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгой, чанарын талаар ярилцаж шийдэхгүй бол Монголоос малын гаралтай тогтвортой бүтээгдэхүүн гарах үндэслэлгүй болно. Платформын ажлын нэг чухал хэсэг нь бэлчээрийн тогтвортой байдлын асуудал байх болов уу, Төр засгийн шийдвэр, бодлогын өөрчлөлт гаргах талд дэмжлэг үзүүлэх явдал гэж бодож байна.

В.Шинээ, МТНП: Баярлалаа! Платформын ажлын үндсэн зорилгуудын нэг нь бодлого, хууль эрх зүйн орчинд чиглэсэн үйл ажиллагаа явуулах юм. Бидний өнөөдрийн хэлэлцүүлэг ч гэсэн тийшээ чиглээд явна гэдэгт итгэж байна. Ингэж байж бодит үр дүнд хүрэх байх.

Н.Ганхуяг, МБАНХ: Өмнөх асуудалтай холбоотой нэг санал хэлэх гэсэн юм. Плафтормын ажлын төлөвлөгөө, санхүүжилтийн үлдэгдэлтэй холбоотойгоор 21 оныг хүлээхгүйгээр хэрэгжүүлж болох ажлууд, тулгамдсан асуудлууд байна. Тухайлбал, энэ жил баруун чиглэлийн Говийн Бүсийн 4-5 аймгийн малчид гачиг ихтэй учир отор нүүдэл хийж яваа, тэнд өвөлжилт хүндрэх эрсдэлүүд үүссэн гэх мэт асуудлууд байна. Манай Холбоо 100 гаруй суманд 80,000 гаруй малчин өрхийн гишүүнчлэлтэй. Бид малчид, хоршоодтойгоо өдөр тутам уулзаж ажил төрлөө амжуулахад хүндрэлтэй байдаг. Ялангуяа интэрнэтийн асуудал, цахим уулзалтуудыг хийх техник, тоног төхөөрөмжийн дутагдалтай байдал зэрэг асуудлууд их байна. Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй Хоршоодыг санхүүгээр дэмжих боломжтой юу? Ноолуур бэлтгэлийн улирал, онцлогтой холбоотойгоор бодитой дэмжлэг үзүүлээч ээ гэж хүсэх гэж байна. Шинээ менежерийн дурдсан Техникийн ажлын хэсгийн нэгийг манай Холбоотой хамтран байгуулж болно шүү гэдэг санал хэлье. Алтаа захирлын хэлсэнчлэн Холбооны ажилчдыг чадавхижуулах, гишүүн малчидтайгаа харилцах чадварыг дээшлүүлэх сургалт явуулах тал дээр анхаарч өгөөрөй гэж хүсэх байна.

Х.Хишигжаргал, НҮБХХ: Эрх зүйн орчныг сайжруулах талаар ажиллаач ээ гэдэг санал дээр би нэг хариулт хэлье. Үндсэн ENSURE төслийн хүрээнд биологийн олон янз байдлыг хамгаалахад чиглэгдсэн төсөл байгаа. Биологийн олон янз байдлыг хамгаалахын тулд бэлчээрийн зохистой байдлыг зайлшгүй ярих хэрэгтэй болдог. Тийм учраас ENSURE төслийн хүрээнд бэлчээрийн менежментийг сайжруулах, зэрлэг амьтны бэлчээрийг хангах асуудлаар холбогдох хуулинд өөрчлөлт оруулах чиглэлээр төлөвлөж байгаа ажил байгаа. Тэгэхээр олон газар энэ асуудлыг давхардуулах шаардлагагүй байх гэж бодож байна.

А.Амгалан, FAO UN: Төсвийн санхүүжилтийн талаар асуух асуулт байна. Эхний 8 сарын байдлаар 9%-ийн гүйцэтгэлтэй байгаа юм байна. Үлдсэн нэг улиралд үлдсэн хувийг зарцуулна гэж байна. Энэ жаахан бодит бус санагдаад байна. Эсвэл тийм их эрчимтэй, зарцуулалт өндөр ажил төлөвлөсөн юм уу? Дараагийн асуулт нь, ноолуурын мөшгих тогтолцооны асуудлаар яриагүй мөртлөө тогтвортой байдлын талаар яриад байх юм. Мөшгих тогтолцооны талаар ярьж байгаа юу? Эсвэл дотроо ороод явж байгаа юу?

Гэрчилгээ зөвхөн боловсруулсан ноолуурт өгөгдөх юм уу эсвэл малчнаас эхлээд боловсруулалт хүртэлх үе шатууд орсон байгаа юу?

В.Шинээ, МТНП: Манай баг сая 8 сарын сүүлээр л бүрдлээ. Хийгдсэн байх ёстой судалгааны ажил маань сонгон шалгаруулалтын шатандаа яваа гэх мэт шалтгаанууд байна. Гэсэн ч үлдсэн ажлууд болох GCP зөвлөхүүдийн үйлчилгээнд төлөх 30,000 доллар, судалгааны ажил хийх зөвлөхүүдийн хөлс гэх мэт томхон зардлуудтай ажлууд үлдсэн учраас бид хичээж ажиллана. Мөшгих тогтолцооны хувьд, Технологи гэдэг нэртэй ажлын хэсэг байгуулагдаад энэ чиглэлд бэлчээрээс эхлээд худалдан авагч хүртэл мөшгих тогтолцоо ажиллана. Мөшгих тогтолцоог амжилттай хэрэгжүүлээд явж байгаа санаачлага, үр дүнгүүдийг дэмжиж, хамтарч ажиллана.

Ц.Энх-амгалан, НАМЭМ: Манай төслийн хүрээнд хэрэгжиж буй мөшгих тогтолцоо нь малчны хотноос үйлдвэрийн хаалга хүртэл хийгдсэн байгаа. Манай улсын хувьд мөшгих тогтолцоо, мөшгих тогтолцооны баталгаажуулалтын асуудал их нарийн, комплекс асуудал учраас нүүдлийн МАА онцлогийг тусгасан загвар хэрэгтэй гэдэг дээр санал нэгдэж байгаа. Амьтны тавлаг байдлын үзүүлэлтийг тодорхойлохдоо ч нүүдлийн МАА хувьд өөр онцлогтой гарч ирэх байх. Бид 10 хэдэн жилийн хөдөлмөрийнхөө үр дүн, сайн туршлагыг Платформ-той хуваалцаад явна.

Шинээ, МТНП: Баярлалаа! Өөр санал, шүүмж байна уу?

Б.Бадруун, ХХААХҮЯ: Надад асуулт болон асуултын шинжтэй санал хоёр байна. Удирдах Хорооны баг энэ хэвээрээ байх уу эсвэл арай өөр байдлаар байх уу? Энд яригдаж байгаа зорилго, зорилтууд нь их том хүрээний, улсын шинж чанартай, улс төрийн шинж чанартай байгаад байна. Гэтэл энд сууж байгаа хүмүүсийг харахаар дээд тал нь Яамны газрын дарга, Холбоодын удирдлага, ОУ байгууллагынхан байна. Удирдах Хорооны chair нь гадаад хүн байна. Улсын өөрийнх нь өмчлөл ямар байх вэ? Платформын үйл ажиллагаа тогтвортой байхын тулд улс төрийн дээд түвшинд шилжүүлж өгдөг ч юм уу тэгж байж улс төрийн шийдэлтэй байх ёстой юм биш үү?

И.Конкиевич, Монгол дахь Суурин төлөөлөгч, НҮБХХ: Та их чухал санаа хэлж байна. Хэсэг хугацааны дараа Платформын үйл ажиллагааг ямар байгууллага хариуцаад аваад явах тухай та бид санал бодлоо солилцон, хэлэлцэж шийдвэрлэх юм. Одоогийн байдлаар НҮБХХ Платформын үйл ажиллагааг эхлүүлэх, чиглүүлэх үүрэгтэй оролцож байгаа бөгөөд цаашдаа өөр байдлаар үргэлжлэн ажиллах болно. Удирдах Хорооны гишүүдийн тухайд ч бид хамтын шийдвэр гарган өөрчлөлт оруулж болно. Жишээ нь УИХ-ын нэг гишүүн нэмж элсүүлэх үү? ЗГ-ын эсвэл Яамны төлөөлөгч эсвэл Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар гэх мэт тогтвортой ноолууртай холбоотой шийдвэр гаргах түвшний хүн байвал ямар вэ? Би зөвхөн санал оруулж байгаа юм шүү. Та бүхэн хэлэлцэнэ биз. Баярлалаа!

В.Шинээ, МТНП: Саналаа хэлсэн та бүхэнд баярлалаа. Өөр санал байхгүй бол Нэгдсэн Хуралдаан зохион байгуулах тухай асуудал руу орох уу? Нэгдсэн Хуралдаан гэдэг маань Платформын загварт нилээн чухал үүрэгтэй. Бүх талууд нэг дор цуглаад хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлах ажил байгаа юм. Энэ оны анхдугаар хурлаараа Платформын зорилго, бүтцийг олон нийтэд таниулах, тогтвортой ноолуурын талаар гаргасан тодорхойлолтоо танилцуулж зөвшилцөлд хүрэх юм. Сая Бадруун даргын хэлдгээр Платформыг урт хугацаандаа хэн авч явах, үйл ажиллагааны зарчим нь ямар байх талаар санал нэгдэнэ. Мөн суурь судалгааны үр дүнг хэлэлцэх, хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний үндсэн суурь нь гарч ирэх юм. Анхдугаар хурлыг 11 сарын 20-нд хийхээр төлөвлөж байна. Та бүгдийн саналыг сонсьё. Малчдын төлөөллийг

оролцуулсан, зааландаа 100-150 хүнтэй, 50-60 гадаадын түнш оролцогчид онлайн хэлбэрээр оролцох ийм хэмжээний хурал болох юм. Арга хэлбэр дээр нь саналаа хэлнэ үү? Хэлэлцэх асуудлуудын талаар өгөх та бүгдийн санал бас үнэтэй байна. MOU маягийн хамтын ажиллагааны санал дээр гарын үсэг зурах үйл ажиллагаа бас хурлын үеэр явагдана. Энэ бичиг баримтыг боловсруулах, зөвлөх тал дээр хамтран ажиллана уу гэж та бүхнээс хүсье. Хугацааны хувьд та бүхэн санал нийлж байна уу?

Хурал хийхээр төлөвлөсөн өдрийг гишүүд зөвшөөрч батлав.

Т.Булган, БОАЖЯ: Бидэнд сайн туршлага байгаа. Банкны Холбоотой нийлээд ТОС Форум гэж жил болгон зохион байгуулаад хэвшчихсэн. Цаашдаа Платформыг хэн, яаж авч явах вэ гэдэг дээр ТОС холбооны жишээ их сайн жишээ. Төр засгаас дэмжээд, төсөл хөтөлбөр дээр хамтраад ажилладаг. Гэхдээ Платформын хувьд малчид бас ороод ирж байгаа болохоор онцлог байдлаа хадгалсан хувилбаруудаа гаргаад явах ёстой байх.

Ц.Эрдэнэбат, МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын Газар: Надад нэг санал байна. ХХААХҮЯ-ны харьяа ХАА Бирж гэж байгаа. Хурлын зохион байгуулалтын ажилдаа энэ Биржийг татаж оролцуулбал танай ажилтай нилээн уялдахаар харагдаж байна.

Шинээ, МТНП: Бид мэдээллийг цаг тухайд нь та бүхэнд явуулаад байх учраас та бүхэн тухай бүрд нь санал, зөвлөмжөө хуваалцаад явахыг хүсье.

О.Одгэрэл, МТНП: Платформын мэдээлэл харилцааны стратеги төлөвлөгөөг танилцуулав.

В.Шинээ, МТНП: Мэдээлэл харилцааны тал дээр бидний төлөвлөж байгаа бас нэг ажил бол Interagency communication group буюу агентлаг хоорондын мэдээлэл харилцааны бүлэг юм. Платформын дэргэдэх мэдээлэл харилцааны Платформ гэсэн үг. Мэдээ мэдээллийг илүү өргөн сувгаар олон нийтэд хүртээмжтэй байдлаар хүргэх, таниулан сурталчлах, үйл ажиллагаа нэгтгэх зорилгоор ийм бүлэг ажиллуулахаар төлөвлөсөн байгаа.

Ц.Энх-амгалан, НАМЭМ: Target group-ээ тодорхой болгоод үүндээ малчдыг оролцуулан тогтвортой ноолуурын талаар малчдад мэдээ мэдээллийг сайн хүргэх хэрэгтэй байгаа. Манай орны хувьд бас сайн сонирхолтой арга туршлагууд байна. Жишээ нь: Экологийн цагдаагийн иргэдэд өгч байгаа мэссэж үндэстний ёс заншил, шашин, итгэл үнэмшилд тулгуурласан их сонирхолтой агуулга, хэлбэртэй байсан. Энэ арга барилыг бас тусгаарай.

Т.Булган, БОАЖЯ: Нэг асуулт байна. Хүснэгт 2 дээр “нөөцийн ашиглалтанд нөлөөлөх байдал” гэж үзүүлэлт байна. Энэ ямар учиртай үзүүлэлт вэ? Оноогоор яаж үнэлгээ хийгээд байна вэ? Ямар агуулгатай вэ? Орчуулгаа илүү ойлгомжтой, тодорхой болгоорой.

О.Одгэрэл, МТНП: Агуулга нь шийдвэр гаргалтанд нөлөөлөх нөлөөлөл болон тухайн алхмыг хийхээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх нөөц чадвар хэр вэ гэдэг талаас нь үнэлгээ хийсэн юм байналаа.

А.Амгалан, FAO UN: Нэг санал байна. Нэгдсэн Хуралдаанаа өргөн хүрээнд их ач холбогдол өгч зохион байгуулах гэж байгаа юм байна. Тийм болохоор ач холбогдлынх нь түвшнээр ХХААХҮЯ эсвэл Ерөнхийлөгчийн Тамгын Газрын хүрээнд зохион байгуулах боломж байгаа юу? Ач холбогдол нь ч өндөрсөөд, оролцоо ч улам нэмэгдээд явах байх. Одоогийн байдлаар бол зөвхөн НҮБХХ-ийн ажил юм шиг ойлгогдох гээд байна.

И.Конкиевич, Монгол дахь Суурин төлөөлөгч, НҮБХХ: Санал бодлоо хуваалцсан танд баярлалаа, бид гарцаагүй анхаарч үзэх болно. Платформын нь олон оролцогч талуудаас бүрдсэн байдаг тул нээлтийн ажилд засаг захиргааны нэгжийг бас оролцуулах нь зүйтэй.

Хэрхэн яаж илүү олон оролцогч талуудыг хамарсан хурал хийх вэ гэдэг дээр бид ажиллах шаардлагатай гэж бодож байна. Харин өмчлөлийн хувьд ХХААХҮЯ байж болох ч Платформ өөрөө хамтын, нэгдсэн үйл ажиллагааг хангах зорилготой учраас Платформын цаашдын ажилд хамааралгүй янз бүрийн оролцогч талуудын хамт Платформын нээлтэнд бэлтгэх, эхлүүлэх ажилд оролцох зарим загварыг бид авч үзэх хэрэгтэй байх. Санал бодлоо илэрхийлсэн та бүхэнд болон мэдээлэл харилцааны стратегийг танилцуулсан Одгэрэлд баярлалаа. Бид мэдээлэл харилцааны стратегийг аль оролцогч талд зориулан танилцуулж байгаагаас хамаараад онцлог талыг нь тусгаад явах болно. Үнэтэй зөвлөгөө, санал хэлсэн та бүхэнд маш их баярлалаа!

Шинээ, МТНП: Юуны өмнө Удирдах Хорооны хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд маш их баярлалаа! Хэлэлцэхээр зорьсон асуудлуудаа хэлэлцчихлээ. Өнөөдөр эхний 3 улиралд хийгдсэн ажлын явцыг танилцууллаа. Үлдсэн 1 улиралд далайцтай олон ажил төлөвлөсөн байгаа. Хамтран хэрэгжүүлэх боломжтой ажил, судалгааны санал байвал бидэнтэй холбогдоорой. Мөн чадавхи бэхжүүлэх хүрээнд хэд хэдэн санал дэвшүүлсэн байгаа. Заавал 21 он гэхгүй хэрэгжүүлээд үр дүн гараад явчих ажлууд бий. Ганхуяг захирлын дурдсан бүс нутаг, аймгуудад зуншлага хүндрэлтэй, нөхцөл байдал хүнд байгаатай холбогдуулан энэ тал дээр анхаарч ажиллая. Улс төрийн шийдэл хэрэгтэй гэдэг нь маш зөв санал, санаачлага байна. Бид анх УХ-г байгуулж байхдаа ямар түвшний гишүүд байх, ямар оролцоотой байх вэ гэдэг дээр нилээн удаан хэлэлцсэн. Ингээд эцэст нь одоогийн бүрэлдэхүүнтэй байхаар шийдсэн. Цаашдаа Платформыг үндэсний хэмжээнд манлайлалтай болгоод авч явах тал дээр урт хугацааны төлөвлөгөөндөө тусгахаар тэмдэглэж авлаа. Нэгдсэн Хурлын өдрийг тогтлоо. Орон нутгийн иргэд, малчдыг оролцуулах тал дээр анхаарья. Нэгдсэн Хуралдааны бэлтгэл маягаар салбар хуралдаануудыг хийх саналыг их зөв гэж бодож байна. Энэ салбар хуралдаануудаар Нэгдсэн Хуралдааны session-үүдийнхээ сэдэв, хэлэлцэх асуудлуудыг тодорхойльё. Мэдээлэл харилцааны стратеги дээр Монголынхоо сайн туршлага, санаачлагуудыг судалж нэвтрүүлье. Монгол хувилбар дээр дахин ажиллаад та бүгдэд танилцуулья.

И.Конкиевич, Монгол дахь Суурин төлөөлөгч, НҮБХХ: Та бүхнийг УХ-ны хуралд хүрэлцэн ирсэнд дахин талархлаа илэрхийлье! Тогтвортой ноолуурын платформын хөгжил нь хамтын хүчин чармайлтын үр дүнгээр хэмжигдэх бөгөөд, Платформын үйл ажиллагаанд НҮБХХ-ын зүгээс хамааралтай бүх оролцогч талуудыг нэг ширээнд суулгах, хамтын хэлэлцүүлэг, ноолуурын салбарын болоод малчдын эрэлт хэрэгцээг хамтад нь авч хэлэлцэх орон зай олгогч, чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэх юм. Тиймээс таны оруулсан хувь нэмэр, шууд нөлөө, санал сэтгэгдлийг бид маш их үнэлдэг билээ. Энд хөндөгдсөн асуудлуудыг тусгасан имэйлийг бид та бүхэнд явуулах болно. Мөн мэдээлэл харилцааны төлөвлөгөөг хянаад ойрын хэдэн долоо хоногийн хугацаанд цахим хэлбэрээр батлуулахаар та бүхэнд илгээх болно. Платформын менежер Шинээ өнөөдөр дурдсан асуултуудыг илүү нарийвчлан авч үзэх байх. Удирдах Хорооны гишүүдэд өөрчлөлт оруулахтай холбогдуулан, УИХ-аас нэг гишүүн нэмж оруулах уу? Энэ тал дээр бид таны санал бодлыг сонсох хэрэгтэй байна. УИХ-ын гишүүн нэмэхэд татгалзах зүйл байна уу эсвэл дэмжиж байна уу? Эсвэл бид удирдах гишүүдийг энэ хэвээр нь байлгах уу?

Ц.Эрдэнэбат, МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын Газар: Улс төрийн дэмжлэг үзүүлдэг хүний оролцоо нэмэгдэх тусмаа сайн. Гэхдээ яг УИХ-ын гишүүн гэдгээрээ биш тухайн гишүүн энэ ажил дээр champion болоод явах, салбарт туршлагатай хүн байвал зүгээр байх. Миний

бодлоор энэ тухай яг одоо шийдэх биш харин Нэгдсэн Хуралдаан дээр оролцоог харж байгаад шаардлагатай бол тэндээс сонгосон нь дээр байх.

И.Конкиевич, Монгол дахь Суурин төлөөлөгч, НҮБХХ: Бидний энд хэлэлцэж буй асуудлыг УИХ-д бас ажил хэрэг болгон хэлэлцдэг гишүүнийг нэмэх нь маш зөв санал байна. Энэ тухайд имэйл-ээр үргэлжлүүлэн хэлэлцье. Нэгдсэн хуралдааныг 11-р сарын 20-ны өдөр зохион байгуулна гэдэгт бид бүгд санал нэгдлээ. Монгол Улсын хувьд их чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болно гэдэгт итгэлтэй байна. Платформын баг Нэгдсэн Хуралдаанд хичээнгүйлэн бэлдэж ажиллах бөгөөд таны дэмжлэг, оруулсан хувь нэмэр маш их үнэ цэнэтэй байх болно. НҮБХХ-ийн бусад орнуудад түүхий эдийн платформыг амжилттай үүсгэж, чиглүүлж өгсөн амжилттай туршлага байгаа хэдий ч энэ Платформын хувьд ширхэгт, тэр дундаа ноолуурын салбарт үүсгэж байгаа анхны Платформ болох юм. НҮБХХ энэ санаачлагад оролцож, бодитоор хэрэгжүүлэх боломжтой болсондоо түйлын их баяртай байна. Энэхүү Платформын Монгол улсад өгөх урт хугацааны ашиг тустай байдлын төлөө зориулах таны дэмжлэг, нөлөө мөн мэдээлэл түгээх сүлжээнд бид маш их ач холбогдол өгч байна. Үнэтэй цагаа зарцуулан хүрэлцэн ирсэнд дахин баярлалаа!

Шийдвэр:

1. Нэгдсэн Хуралдааныг 2020 оны 11 сарын 20-нд зохион байгуулахаар батлав;
2. Удирдах Хорооны гишүүний тоог нэгээр нэмж УИХ-ын гишүүн элсүүлэх тухай имэйл-ээр үргэлжлүүлэн хэлэлцэхээр шийдэв;
3. МТНП-ын Мэдээлэл, харилцааны стратеги төлөвлөгөөг дахин нягталж боловсруулаад УХ-ны гишүүдэд имэйл-ээр илгээн цахим хэлбэрээр батлуулахаар шийдэв.

Батлав:

…….. Илейн Конкиевич, НҮБХХ-ын Суурин төлөөлөгч

Тэмдэглэл хөтөлсөн:

..... Н.Цолмон, Платформын Ажилтан

Хянасан:

..... Х.Хишигжаргал, НҮБХХ-ийн шинжээч